

## **МББСБХолбооны Удирдах Зөвлөлийн хурлын дэгийн журам**

### **Нэг. Хурлын дэг**

- 1.1 Удирдах зөвлөлийн хурлыг МББСБХолбооны ерөнхийлөгч даргална. Түүний эзгүйд болон түүний чөлөөт цагт хурлыг Удирдах Зөвлөлийн / УЗ / гишүүдийн ердийн олонхийн санал авсан гишүүн удирдан явуулна.
- 1.2 Хурлаар хэлэлцэх асуудлыг Холбооны дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд хариуцсан хороон даргын саналаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөн оруулна. Хурлаас нэг хоногийн өмнө хэлэлцэх асуудлыг УЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн байна.
- 1.3 УЗ-ийн хуралд гишүүн ББСБ-ууд оролцох эрхтэй ба тухайн ББСБ-ыг төлөөлөх эрх бүхий этгээд байх ба ажиглагчийн статустай байна. Санал хүсэлтээ УЗ-ийн хурлын “Бусад асуудал” гэсэн хэсэгт гаргана.
- 1.4 УЗ-ийн хуралд УЗ-ийн гишүүн ББСБ-аас нэг хүн төлөөлөх эрхтэйгээр оролцох ба нэгээс илүү хүн оролцохоор бол зөвхөн ажиглагчийн статустай оролцож болно.
- 1.5 УЗ-ийн хурал хяналтын зөвлөлийн гишүүдийг оролцуулан хуралдаж болох ба түүнийг хурал даргалагч хуралдаанаас өмнө шийдсэн байх ба хурлаар хэлэлцэх асуудлыг нэг хоногийн өмнө хүргүүлсэн байна.
- 1.6 Хяналтын зөвлөлийн гишүүд УЗ-ийн хуралд оролцохдоо шийдвэр гаргах саналын эрхгүй ба хурлаар хэлэлцэгдэх бүх асуудалд өөрийн байр суурь саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.
- 1.7 Хурал даргалагч тухайн хурлаар хэлэлцэж буй асуудлын ач холбогдол, хурлын ачаалал зэргээс хамааруулан санал, шүүмжлэл тавих үргэлжлэх хугацааг тогтоох, асуулт тодруулга авах зэргээр тухайн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулна.
- 1.8 Хуралд оролцогчид харилцан бие биенээ хүндэтгэн, асуудалд ажил хэрэгч, зарчимч байр суурьнаас хандан соёлтой оролцоно.
- 1.9 Хуралдааны үйл явц, зохион байгуулалттай холбоотой хуралдаан даргалагчийн шаардлагыг оролцогчид биелүүлэх үүрэгтэй.
- 1.10 Хурал даргалагчийн шаардлагыг удаа дараа биелүүлээгүй тохиолдолд хурал даргалагч түр завсарлуулах, хойшлуулах, эсвэл ёс зүйн дүрмийн хүрээнд асуудлыг тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

## **Хоёр. Бусад зүйл**

- 2.1 УЗ-ийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэх үед гишүүн ББСБ-уудыг оролцуулахгүй:
  - 2.1.1 Шагналд тодорхойлох, шалгаруулах үед
  - 2.1.2 Гишүүний ёс зүйн асуудал хэлэлцэх үед
- 2.2 Гишүүн ББСБ-ууд хуралд оролцож байх үед дээрх асуудлуудыг хэлэлцэх бол хурал даргалагчийн шаардлагаар хурлын танхимыг түр орхиж гарах ёстой.
- 2.3 Удирдах зөвлөлийн гишүүн ББСБ-ын хувьд гишүүний ёс зүйн асуудал хэлэлцэгдэж байгаа үед хуралд оролцохдоо тайлбар, тодруулга хийх эрхтэй ба эцсийн шийдвэр гарах үед хурлын танхимыг түр чөлөөлж өгөх үүрэгтэй.
- 2.4 Удирдах зөвлөлийн гишүүний өгсөн байр суурь, шийдвэрийг тухайлан мэдээлэхийг хориглоно.

## **МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО**